



Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийн онцлог зохицуулалтууд

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл холбогдно уу:



**ДАШНЯМЫН
ЗОЛЖАРГАЛ**

Ахлах Партнер
+976 7013-1020

zola.dashnyam@dblaw.mn



**ТУУЛЫН
СУВД**

Хуульч

+976 7013-1020

t.suvd@dblaw.mn

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 тоот тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” баримт бичгээр одоо хүчин төгөлдөр хэрэгжиж буй 1997 онд анх батлагдсан Дампуурлын тухайн хууль (цаашид “**Одоогийн хууль**” гэх)-ийг 2021 онд багтаан шинэчлэн найруулж батлах зорилт тавьсан.

2019 онд анхны төсөл нь гарсан Дампуурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь олон нийт, эрдэмтэн судлаач, хуульч, шүүгч нараас санал асуулга авсны үндсэн дээр засвар орж, нэрээ өөрчлөн Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль (цаашид “**Хуулийн төсөл**” гэх) болсон бөгөөд одоогийн байдлаар олон нийтээс санал асуулга авах шатандаа яваа бөгөөд Улсын Их Хуралд хараахан өргөн баригдаагүй байна.

Хуулийн төслийн зорилго

Энэхүү Хуулийн төслөөр санхүүгийн дэд бүтцийн эрх зүйн орчныг сайжруулан улмаар хөрөнгө оруулагчид, зээлдүүлэгчдэд учирч болзошгүй эрсдэлийг бууруулан санхүүгийн салбарыг бэхжүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ¹ гэж үзжээ.

Танилцуулга

Энэхүү Хуулийн төслийг боловсруулахад НҮБ-ын Худалдааны хууль тогтоомжийн хорооноос 2004 онд боловсруулсан Дампуурлын хуулийн загварыг суурь болгон ашигласан байна.²

Хуулийн төслөөр хуулийн этгээдийн төлбөрийн чадвартай эсэхийг тогтоох, төлбөрийн чадваргүйдлийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх, нэхэмжлэлийн шаардлага гаргах, түүнийг хангах, хэрэг гүйцэтгэгчийн эрх хэмжээ, түүнийг томилох, чөлөөлөхтэй холбоотой зохицуулалт, үүрэг гүйцэтгүүлэгчдийн хурал, түүний эрх хэмжээ, эвлэрэл, төлбөрийн чадваргүй хуулийн этгээдийг дахин зохион байгуулах, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахад зорилго нь оршино.³

Хуулийн төсөлд орсон гол зарчмын шинжтэй өөрчлөлтүүд

1. Хуулийн төслийн үйлчлэх хүрээ:

Банкны системийн онцлогоос шалтгаалан банкны дампуурлын асуудлыг банкны хуулиар зохицуулахаар, даатгал, банк бус санхүүгийн байгууллага зэрэг санхүүгийн байгууллагын хувьд тэдгээрийн төлбөрийн чадваргүйдэлтэй холбоотой нарийвчилсан харилцааг тус тусын хуулиар, нийтлэг харилцааг энэ хуулиар зохицуулахаар тусгасан.⁴ Мөн энэхүү хуулиар зохицуулаагүй харилцааг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулахаар оруулсан байна. Мөн Одоогийн хуульд байгаа “хариуцагч” гэх ойлголтыг “үүрэг гүйцэтгэгч” гэх ойлголтоор орлуулсан байна.

2. Төлбөрийн чадваргүйд тооцох аргачлал:

Одоогийн хууль	Хуулийн төсөл
Төлбөрийн чадваргүйд тооцох үндэслэлийг хуулийн этгээдийн өөрийн хөрөнгийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний үүргээ хууль буюу гэрээнд заасан хугацаанд биелүүлээгүйтэй ⁵ холбож тооцдог.	Одоогийн хуулийн аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэн өөрчилж төлбөрийн чадваргүйд тооцох үндэслэлийг бэлэн мөнгөний урсгал болон балансын аргын хосолсон аргачлалаар тооцохоор Хуулийн төсөлд тусгасан байна. ⁶ Үүнд: хууль эсхүл гэрээнд заасан мөнгөн төлбөрийн үүргээ үргэлжилсэн 6 сараас дээш хугацаагаар биелүүлж чадаагүй; эсхүл өр төлбөр нь хуулийн этгээдийн санхүүгийн тайланд тусгагдсан нийт хөрөнгийн дүнгийн 50 хувиас хэтэрсэн бол төлбөрийн чадваргүйд тооцохоор Хуулийн төсөлд заасан байна. ⁷

3. Нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлага:

Одоогийн хуулиар нэхэмжлэлийн шаардлагыг баталгаажуулах ажиллагааны талаар нарийвчлан зохицуулаагүйгээс нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа үндэслэлгүйгээр нэмэгдүүлэх сөрөг практик үүссэн бөгөөд үүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор нэхэмжлэлийн шаардлага гаргах, түүнийг баталгаажуулах, шаардлагыг хангуулахтай холбоотой ажиллагааны талаарх зохицуулалтууд орсон байна.⁸

⁴ *Id.*

⁵ Одоогийн хууль, 4.1-р заалт,

⁶ Хуулийн төслийн танилцуулга,

⁷ Хуулийн төсөл, 22.1-р заалт,

⁸ Хуулийн төслийн танилцуулга,

№	Одоогийн хуульд нэхэмжлэлийн шаардлагыг хангах дараалал байхгүй тул Иргэний хуулийн 32.5-т заасан дараах дарааллаар хангахаар зохицуулсан ба хэрэв татан буугдаж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй бол түүний эд хөрөнгийг төлбөл зохих төлбөрийн хэмжээнд хувь тэнцүүлэн зохих дарааллын дагуу харилцагчдад хуваарилна. Үүнд:	Харин Хуулийн төсөлд нэхэмжлэлийн шаардлагыг дараах дарааллаар хангах ба хуваарилагдах хөрөнгө доорх өр төлбөрийг төлөхөд хүрэлцэхгүй бол ижил шатлалд байгаа шаардлагыг хувь тэнцүүлэн хангана. Үүнд: ⁹
1	бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгуулах, татварын өрийг хураах болон шүүхийн шийдвэрээр гаргуулах бусад төлбөр;	Бусдын амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд гэм хор, хохирол учруулсны төлбөрийг ганцаарчлан албадан гүйцэтгэх ажиллагаа хийж болно;
2	хэрэг гүйцэтгэгч буюу татан буулгах комисс, тэдгээртэй адилтгах бусад этгээдийн эрх, үүргийнхээ хүрээнд гүйцэтгэсэн үйл ажиллагааны зардал;	төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааны зардал;
3	дампуурлын үед хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх явцад байгуулсан гэрээ, хэлцлийн дагуу гаргасан шаардлага;	
4	хадгаламжийн албан журмын даатгалын нөхөн төлбөр;	
5	хадгаламж эзэмшигчийн мөнгөн хөрөнгө;	
	хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдад төлөх хөдөлмөрийн хөлс;	ажилтны цалин, олговор, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал болон хөдөлмөрийн болон хамтын гэрээгээр хүлээсэн бусад өр төлбөр;
6		үүрэг гүйцэтгэгчийг дахин хөрөнгөжүүлэх болон дахин зохион байгуулах зорилгоор төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлснээс хойш бий болсон өр төлбөр;
7		барьцаат нэхэмжлэлийн шаардлага;
8		энгийн нэхэмжлэлийн шаардлага;
9		барьцаа хөрөнгийн үнэлгээний зөрүүгээр төлөгдөөгүй үлдсэн өр төлбөр;
10		доод эрэмбийн шаардлага ¹⁰ ; *** Шүүхээс төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэхийг зөвшөөрсөн захирамжид доод эрэмбийн нэхэмжлэлийн шаардлагыг гаргаж болохоор заасан бол хангана. Доод эрэмбийн шаардлага гэдэгт үүрэг

⁹ Хуулийн төсөл, 84.1-р заалт,

¹⁰ Хуулийн төсөл, 40-р заалт,

		гүйцэтгэгчийн хариу төлбөргүй гүйцэтгэх үүрэг; үүрэг гүйцэтгүүлэгчид төлбөрийн төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаанд оролцсоны улмаас бий болсон зардал; мөн хувь нийлүүлэгчээс олгосон зээл, түүнтэй адилтгах шаардлага хамаарна.
11		дээрх өр төлбөр, шаардлагуудыг барагдуулсны дараа түүнээс үлдсэнийг нь хувьцаа эзэмшигчдэд оруулсан хөрөнгөнд нь хувь тэнцүүлэн хуваарилна. ¹¹
12	хууль тогтоомжид заасны дагуу бусад этгээдтэй хийх тооцоо.	

4. Хэрэг гүйцэтгэгчид тавигдах шаардлага:

Одоогийн хуулиар хэрэг гүйцэтгэгч нь аливаа зөвшөөрөл авсан байх шаардлага байхгүй байгаа бол Хуулийн төслөөр хэрэг гүйцэтгэгч нь Хууль зүй, дотоод хэргийн яамнаас эрх авсан хувь хүн, хуулийн этгээд байх бөгөөд хэрэв хэрэг гүйцэтгэгчид ашиг сонирхлын зөрчил байгаа тохиолдолд шүүх томилохоос татгалзах мөн чөлөөлөх эрхтэй байхаар тусгасан нь хэрэг гүйцэтгэгчид итгэх итгэлийг нэмэгдүүлэх, хариуцлага тооцох боломжийг бий болгосон гэж үзэж байна.

5. Нэгэнт байгуулагдан хүчин төгөлдөр хэрэгжиж буй гэрээ хэлцлүүд:

Одоогийн хуулиар хариуцагчийн хуваарилагдах эд хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх үүднээс шүүх нэхэмжлэгчдийн хурал /зөвлөл/-аас санал болгосноор хариуцагчийн биелэгдээгүй байгаа, эсхүл ихэнх хувь нь биелэгдээгүй гэрээг өөрчлөх, цуцлах эрхтэй¹² гэж заасан байх боловч хэрхэн өөрчлөх, цуцлах талаар нарийвчлан заагаагүй. Харин Хуулийн төслөөр энэ асуудлыг дараах байдлаар илүү дэлгэрэнгүй, нарийвчлан зохицуулсан байна. Үүнд:

№	Үүрэг гүйцэтгэгчийн байгуулсан хэлцлүүд	Үүрэг гүйцэтгэгчээс шаардаж болох үүргийн гүйцэтгэл
1.	Бусдын амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд гэм хор, хохирол учруулсны төлбөрөөс бусад мөнгөн төлбөрийн үүрэг	Түдгэлзүүлнэ.
2.	Тодорхой хуваарийн дагуу биржийн үнээр хийсэн хэлцэл	Уг хэлцлийн үүргийг төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлснээс хойш биелүүлэхээр байгаа бол үүргийн гүйцэтгэлийг шаардахгүй, үүргээ гүйцэтгээгүйн улмаас бий болох бодит хохирлыг шаардаж болно.
3.	Барьцаагаар хангагдаагүй хөдлөх эд хөрөнгө худалдан авах гэрээ	Уг хэлцлийн дагуу эд хөрөнгийг эзэмшилдээ авсан боловч үнийг төлөөгүй, үүрэг гүйцэтгэгчид эд хөрөнгийн өмчлөх эрх шилжээгүй байгаа бол хариу төлбөрийг төлөх эсэхийг хэрэг гүйцэтгэгч шийдвэрлэнэ. ¹³
4.	Хөдлөх эд хөрөнгө худалдан авах гэрээ	Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэхээс өмнө үүрэг гүйцэтгэгч хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг эд хөрөнгийн үнийг төлөх хүртэл өөртөө үлдээж гэрээний

¹¹ Хуулийн төсөл, 84.3-р заалт,

¹² Одоогийн хууль, 20.1-р заалт,

¹³ Хуулийн төсөл, 64.1-р заалт,

		зүйлийг худалдан авагчийн эзэмшилд шилжүүлэх замаар худалдсан бол эд хөрөнгийн үнийг төлсөн худалдан авагч өмчлөх эрхийг шилжүүлэхийг шаардаж болно. ¹⁴
5.	Үл хөдлөх эд хөрөнгө, ажлын байр түрээслэх, хөлслөх гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ	Дээрх гэрээний дүнд үүрэг гүйцэтгэгчийн хуваарилагдах хөрөнгийн хэмжээ нэмэгдэхээр бол уг гэрээний үүргийг үргэлжлүүлнэ. ¹⁵ Өөрөөр бол цуцална.
6.	Үл хөдлөх эд хөрөнгө түрээслэгч, хөлслөгчийн хувиар байгуулсан хөлслөх, түрээслэх гэрээ	Үүрэг гүйцэтгэгчийн үл хөдлөх эд хөрөнгө түрээслэгч, хөлслөгчийн хувиар байгуулсан хөлслөх, түрээслэх гэрээг гэрээнд заасан цуцлах мэдэгдэл өгөх хугацаанаас үл хамааран хэрэг гүйцэтгэгч Иргэний хуульд заасан журмын дагуу цуцалж болно. ¹⁶
7.	Ажил гүйцэтгэх гэрээ	Үүрэг гүйцэтгэгчийн захиалагчийн хувиар байгуулсан ажил гүйцэтгэх гэрээг гэрээнд өөрөөр зааснаас үл хамааран хэрэг гүйцэтгэгч болон гэрээний нөгөө талын санаачилгаар цуцална. ¹⁷
8.	Хуваарилагдах хөрөнгөтэй холбоотой өгсөн аливаа даалгавар	Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхэлснээр дуусгавар болно. ¹⁸
9.	Хуваарилагдах хөрөнгөтэй холбоотой олгосон итгэмжлэл	Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхэлснээр дуусгавар болно. ¹⁹

7. Шүүхээс хүчин төгөлдөр бусад тооцох хэлцлүүд:

№	Одоогийн хуулиар хариуцагчийн хийсэн дор дурдсан гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр бус байна. ²⁰ Үүнд:	Үүрэг гүйцэтгэгчийн байгуулсан дараах хэлцлүүд хүчин төгөлдөр бус байна. Үүнд: ²¹
1.	Дампуурлын хэрэг үүсгэхээс өмнө 2 жилийн дотор хариу төлбөргүйгээр хариуцагчийн удирдах байгууллагын гишүүд, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх тухай гэрээ, хэлцэл;	Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлт гаргахаас өмнөх 2 жилийн дотор байгуулсан хариу төлбөргүйгээр үүрэг гүйцэтгэгчийн хувьцаа эзэмшигч, гишүүн, эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн өмчлөлд хөрөнгө шилжүүлэх тухай гэрээ, хэлцэл;
2.	Дампуурлын хэрэг үүсгэхээс өмнө 1 жилийн дотор хариу төлбөргүйгээр энэ хуулийн 1-т зааснаас бусад этгээдийн өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх тухай гэрээ, хэлцэл;	Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлт гаргахаас өмнөх 1 жилийн дотор байгуулсан хариу төлбөргүйгээр 1-т зааснаас бусад этгээдийн өмчлөлд хөрөнгө шилжүүлэх тухай гэрээ, хэлцэл;
3.	Дампуурлын хэрэг үүсгэхээс өмнө 1 жилийн дотор бусдад илт давуу байдлаар эд хөрөнгө худалдах, үйлчилгээ үзүүлэх тухай гэрээ, хэлцэл;	Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлт гаргахаас өмнөх 1 жилийн дотор байгуулсан бусдад илт давуу байдлаар

¹⁴ Хуулийн төсөл, 64.3-р заалт,

¹⁵ Хуулийн төсөл, 65.1-р заалт,

¹⁶ Хуулийн төсөл, 66.1-р заалт,

¹⁷ Хуулийн төсөл, 66.6-р заалт,

¹⁸ Хуулийн төсөл, 67.1-р заалт,

¹⁹ Хуулийн төсөл, 68.1-р заалт,

²⁰ Одоогийн хууль, 19.1-р заалт,

²¹ Хуулийн төсөл, 70.1-р заалт,

		хөрөнгө худалдах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх тухай гэрээ, хэлцэл;
4.	Тодорхой нэхэмжлэгчдэд давуу эрх олгох зорилгоор дампуурлын хэрэг үүсгэхээс өмнө 120 хоногийн дотор хийсэн гэрээ, хэлцэл;	Тодорхой үүрэг гүйцэтгүүлэгчид давуу эрх олгох зорилгоор төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлт гаргахаас өмнөх 120 хоногийн дотор байгуулсан гэрээ, хэлцэл;
5.	Дампуурлын хэрэг үүсгэснээс хойш энэ хуулийг зөрчиж хийсэн гэрээ, хэлцэл.	Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлт гаргаснаас хойш энэ хуулийг зөрчиж хийсэн гэрээ, хэлцэл;
6.		Үүрэг гүйцэтгүүлэгч, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх хүсэлт гаргахаас өмнөх нэг сарын дотор, эсхүл энэ хүсэлтийг гаргасны дараа үүрэг гүйцэтгэгчийн хуваарилагдах хөрөнгөнд хамаарах хөрөнгөнд барьцааны эрх олж авсан бол уг эрх ²² .

8. Төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг дуусгавар болгох болон зогсоох:

Одоогийн хуульд “татан буулгах ажиллагааг дуусгавар болгох” гэдэг ойлголт байгаа ба татан буулгах ажиллагаа дуусгавар болсноор хариуцагч нэхэмжлэлийн хангагдаагүй шаардлагын үүргээс чөлөөлөгдөж, түүний нэхэмжлэгчдийн өмнө хүлээсэн үүрэг дуусгавар болно²³ гэж тодорхой заасан. Харин Хуулийн төслөөр төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг дуусгавар болгохоос гадна “зогсоох” гэсэн хоёр өөр ойлголтуудыг оруулсан ба эдгээр нь үр дагавараараа ялгаатай байна.²⁴ Үүнд:

Дуусгавар болгох (termination): хуваарилагдах хөрөнгөний эцсийн хуваарилалт хийж дуусмагц шүүх үүрэг гүйцэтгэгчийг татан буулгаж төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг дуусгавар болгох шийдвэр гаргаж үүний дагуу хэрэг гүйцэтгэгч тухайн хуулийн этгээдийг хуулийн этгээдийг бүртгэл болон татварын бүртгэлээс хасуулна. Гэхдээ Одоогийн хуульд байгаа өмнө хүлээсэн үүрэг дуусгавар болох эсхүл чөлөөлөх талаар зохицуулалтыг энд тусгаагүй нь маш учир дутагдалтай буюу ухралт болсон гэж үзэж байна.

Зогсоох (discontinuation): хуваарилагдах хөрөнгө хүрэлцээгүйн улмаас, эсхүл төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг эхлүүлэх үндэслэлгүйн улмаас, эсхүл үүрэг гүйцэтгүүлэгчдийн зөвшөөрлөөр төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг зогсоох бөгөөд ингэж зогсоосноор тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн захиран зарцуулах эрх хэрэг гүйцэтгэгчээс үүрэг гүйцэтгэгчид шилжинэ.

9. Дахин зохион байгуулах ажиллагаа болон дахин хөрөнгөжүүлэх

Одоогийн хуулиар дан ганц дахин хөрөнгөжүүлэх гэх ойлголт байсныг Хуулийн төслөөр “дахин зохион байгуулах ажиллагаа” болон “дахин хөрөнгөжүүлэх” гэж дотор нь хоёр задалсан. Дахин зохион байгуулах ажиллагааг явуулахын тулд дахин зохион байгуулах төлөвлөгөөг Хуулийн төсөлд дурдсан этгээдүүдийн аль нэг нь боловсруулан, шүүх уг төлөвлөгөөг батална. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хэрэг гүйцэтгэгч хяналт тавих ба биелүүлэх боломжгүй болох тохиолдолд тухайн хуулийн этгээдийн өр төлбөрийг барагдуулан, татан буулгах саналыг шүүхэд хүргүүлнэ. Харин дахин хөрөнгөжүүлэх гэдэгт төлбөрийн чадваргүй болсон хуулийн этгээдэд төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлснээс хойш хөрөнгө оруулалт хийхийг ойлгохоор заасан боловч хэрхэн хөрөнгө оруулалт татах, үүрэг гүйцэтгэгчид ямар хууль зүйн боломжуудыг олгох талаар тусгаагүй байна.

²² Хуулийн төсөл, 57.1-р заалт,

²³ Одоогийн хууль, 37.1-р заалт,

²⁴ Н.Баярмаа (LL.M): Дампуурлын хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа: Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанаас ялгагдах онцлог (2021),

Одоогийн хуулиар дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг 2 жилийн дотор хийж гүйцэтгэх ёстой.²⁵ Харин Хуулийн төслөөр энэ хугацааг илүү уртасгасан ба үүрэг гүйцэтгүүлэгчдийн хурлаас төлөвлөгөөг хэрэгжүүлэх илүү урт хугацаа тогтоож болно эсхүл хугацаа тогтоогоогүй бол төлөвлөгөөг 2 жилээс илүүгүй хугацаагаар хэрэгжүүлэх бөгөөд шүүх энэ хугацааг нэг удаа 6 сар хүртэл хугацаагаар сунгаж болохоор тусгажээ.²⁶

Хуулийн төслөөр хуваарилалтын болон хуваарилагдах хөрөнгийг худалдах ажиллагаа нь санал болгосон төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд саад учруулж байвал шүүх үүрэг гүйцэтгэгч, эсхүл хэрэг гүйцэтгэгчийн хүсэлтээр хуваарилалтын болон худалдах ажиллагааг түр зогсооно. Ингэж зогсоох нь хуваарилагдах хөрөнгөнд ашиггүй байдал бий болгох, эсхүл үүрэг гүйцэтгүүлэгчдийн зөвлөл, үүрэг гүйцэтгүүлэгчдийн хурлын аль нэгнээс зөвшөөрөл олгосон тохиолдолд хэрэг гүйцэтгэгчийн гаргасан хүсэлтээр шүүх хуваарилалтын болон худалдах ажиллагааг үргэлжлүүлэхээр шийдвэрлэж болно.²⁷

Хуулийн төсөлд зааснаар төлөвлөгөөг бүрэн биелүүлж дууссан эсхүл төлөвлөгөөг биелүүлж дуусаагүй боловч нэхэмжлэлийн шаардлагыг төлөвлөгөөний дагуу бүрэн хангасан бол хэргийг хэрэгсэхгүй болгож, үүрэг гүйцэтгүүлэгчдийн өмнө үүрэг гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг дуусгавар болж үйл ажиллагаа нь сэргэнэ.²⁸

10. Эвлэрлийн ажиллагаа

Хуулийн төсөлд төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлэхээс өмнөх үед явуулах эвлэрлийн ажиллагааны талаар дэлгэрэнгүй зохицуулсан бүтэн бүлэг оруулж өгсөн. Жишээлбэл, шүүхээс томилсон мэргэжилтэн эвлэрлийн төлөвлөгөөг боловсруулж, бүх үүрэг гүйцэтгүүлэгчид зөвшөөрснөөр шүүх түүнийг батална, мөн төлөвлөгөөний хэрэгжилтэд зөрчил гарсан бол үүрэг гүйцэтгүүлэгч эвлэрлийн ажиллагааг дуусгавар болгож, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэхээр хүсэлт гаргаж болно гэх мэт зохицуулалтууд.

11. Дүгнэлт

Хуулийн төслийг ерөнхийд нь харвал хувь хүнд холбогдох төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг орхигдуулсан мөн дахин зохион байгуулах ажиллагааны хүрээнд хийгдэх дахин хөрөнгөжүүлэх буюу үүрэг гүйцэтгэгчид хөрөнгө босгох нөхцөл боломж, арга замыг хуулиар бий болгоогүй. Мөн төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа дуусгавар болсноор хуулийн этгээдийн хэлбэрээс хамаараад тухайн хуулийн этгээд болон тэдгээрийн хувьцаа эзэмшигч эсхүл гишүүний хүлээх үүрэг дуусгавар болох эсхүл чөлөөлөгдөх эсэх талаар нарийвчлан тусгаагүй байна гэж үзэж байна.

²⁵ Одоогийн хууль, 25.1-р заалт,

²⁶ Хуулийн төсөл, 104.1-р заалт,

²⁷ Хуулийн төсөл, 106-р заалт,

²⁸ Хуулийн төсөл, 117.3-р заалт,